



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар Б/34

Ховд

Б.Түмэнбаярыг даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.9, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын Нэгдсэн эмнэлэгийн даргын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах хүртэл хугацаанд тус эмнэлэгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Баатаржавын Түмэнбаярыг 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Түмэнбаярыг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээний ТҮЭМ-8-3 дахь шатлал 973 165 төгрөг /есөн зуун далан гурван мянга нэг зуун жаран тав/-өөр цалинжуулж, бусад нэмэгдлийг холбогдох хууль, журмын дагуу үндсэн цалингаас тооцож олгохыг тус эмнэлэгийн нягтлан бодогч /Ц.Сүхбат/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Б.Түмэнбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.3147
Zah B/34 Kh